2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ХУРАЛДААНААС БОАЖГ-Т ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

1. Сагсай явах зам дагуу Ногоон хашаан дахь ургалт нь зогссон моднуудыг холбогдох газар болон Өлгий сумын ХТАлбанд хүсэлт тавьж, цэвэрлэх ажлыг зохион байгуулж байна.
2. Төрийн албаны зөвлөлөөс ирэх хүний нөөцийн аудитын бэлтгэл ажлыг хангаж, Салбар зөвлөлөөс заавар зөвлөгөө авч ажиллахаар бэлдэж байна.
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг гарган, заасан хугацаанд нь аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс болон холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БОАЖГАЗРЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

1. Баяннуур, Алтанцөгц суманд Байгаль орчны багц хууль сурталчлах, иргэдээс санал асуулга авах “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа.
2. Аймгийн Цагдаагийн газартай хамтран Сагсай сумын Ойн сан бүхий газраас зөвшөөрөлгүй түлээний мод бэлдсэн эрүүгийн хэрэгт шинжээчийн дүгнэлт гарган ажиллаж байна.
3. “Гранд Рөүд”ХХК-д Хар нуур, Ховд голын сав газрын захиргаанаас гаргасан 2022 онд ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулав.
4. “Хог хаягдал ба түүний менежмент", "Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах, дахин боловсруулахын ач тус" сэдвүүдээр аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах болон дунд ангийн сурагчдад Насан туршийн боловсролын төвтэй хамтарч сургалт зохион явуулж байна. Одоогийн байдлаар Өлгий сумын 1, 2, 3 дугаар ЕБСургуулиуд болон Алтай, Буянт, Баяннуур, Улаанхус, Алтанцөгц сумдын 470 гаруй сурагчид оролцов.
5. Аймгийн МХГазартай хамтран гаргасан удирдамжийн дагуу Баяннуур, Алтанцөгц суманд үйл ажиллагаа явуулж буй ШТСтанцуудад хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонгийн хэрэглээг зогсоож, стандарт шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламжийг байгуулах талаар үүрэг, чиглэл өгч ажиллав.